



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/179

Мандалговь

Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Улсын
аварга шалгаруулах тэмцээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 3.4.1.2, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.1.1 дэх заалтууд болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 7 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Жүдо бөхийн холбоотой хамтран зохион байгуулах Жүдо бөхийн насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах Эрэгтэйчүүдийн 45 дахь удаагийн, Эмэгтэйчүүдийн 30 дахь удаагийн тэмцээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Тэмцээний үйл ажиллагаанд шаардагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100439